



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Аймгийн Эрүүл мэндийн газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: БУА-2024/02/НА-СТА-ТШЗ

| | |
|--|--|
| Цахим хуудас: www.audit.mn Булган аймаг 2023 он | Дарга, тэргүүлэх аудитор: Б.Эрдэнэ Утас: 70342580 Цахим хаяг: erdeneb@audit.gov.mn Аудитын менежер: Ж.Энхцоодол Утас: 70342716 Цахим хаяг: enhtsoodolj@audit.gov.mn Аудитор: А.Сувдаа Утас: 70342495 Цахим хаяг: suvdaaa@audit.gov.mn |
|--|--|

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**БУЛГАН АЙМГИЙН
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс: 7034-2580
E-mail: bulgan@audit.gov.mn

2024.02.23 № 173
танай _____ ны № _____ т

ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГА
П.ОЮУНЦЭЦЭГ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Эрүүл мэндийн газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Эрүүл мэндийн газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон зүйл

“Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Засгийн газрын 2023 оны 241 дүгээр тогтоолын дагуу тус байгууллагын албан хаагчдын үндсэн цалинг 2023 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс шинэчлэн баталсан мөн Засгийн газрын 2022 оны 489 дүгээр тогтоолын нэмэлт өөрчлөлтийн дагуу аймгийн ИТХ-ын 2023 оны XII/01 дүгээр тогтоолоор орон нутгийн нэмэгдлийг олгосон байна. Үүнтэй холбоотойгоор цалин хөлс нэмэгдэл урамшууллын зардал өмнөх оноос 45.2 хувиар өсчээ.

Тайланд онд ДЭМБ-аас 35.5 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг авч Эх хүүхдэд үзүүлэх тусламж болон эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хариу арга хэмжээний чадавхийг бэхжүүлэх төслийг хэрэгжүүлэн ажилласан байна.

006020397

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлуудыг үздэг. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Эрүүл мэндийн газар нь 1 хөтөлбөр 3 зориулалт арга хэмжээний хүрээнд 2,267.5 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөж 2,165.6 сая төгрөгийг зарцуулж 102.6 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Б.ЭРДЭНЭ



Хоёр. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

/төгрөгөөр/

| | Үзүүлэлт | 2022.12.31 | 2023.12.31. |
|--|---|------------------------|------------------------|
| Санхүүгийн байдлын тайлан | | | |
| | Эргэлтийн хөрөнгийн дүн | 367,718,443.3 | 918,868,899.5 |
| | Эргэлтийн бус хөрөнгийн дүн | 251,014,932.4 | 200,481,690.9 |
| | Нийт хөрөнгийн дүн | 618,733,375.7 | 1,119,350,590.4 |
| | Нийт өр төлбөрийн дүн | - | - |
| | Цэвэр хөрөнгө/өмчийн дүн | 618,733,375.7 | 1,119,350,590.4 |
| | Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн | 618,733,375.7 | 1,119,350,590.4 |
| Санхүүгийн үр дүнгийн тайлан | | | |
| | Үйл ажиллагааны орлогын дүн | 4,265,841,668.6 | 3,767,742,547.9 |
| | Үйл ажиллагааны зардлын дүн | 4,237,609,604.2 | 2,837,778,026.6 |
| | Үйл ажиллагааны үр дүн | 28,232,064.4 | 929,964,521.3 |
| | Үйл ажиллагааны бус үр дүн | 129,817,081.7 | 429,347,306.6 |
| | Үйл ажиллагааны нийт үр дүн | (101,585,017.3) | 500,617,214.8 |
| Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан | | | |
| | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 483,566,089.2 | 618,733,375.7 |
| | Тайлант оны үр дүн | 238,163,252.3 | 500,617,214.8 |
| | Эцсийн үлдэгдэл | 618,733,375.7 | 1,119,350,590.4 |
| Мөнгөн гүйлгээний тайлан | | | |
| | Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн | 2,432,212,963.0 | 3,065,441,664.0 |
| | Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн | 2,409,393,163.0 | 2,908,841,664.0 |
| | Үйл ажиллагааны ЦМГ | 22,819,800.0 | 156,600,000.0 |
| | Хөрөнгө оруулалтын ЦМГ | (22,819,800.0) | (156,600,000.0) |
| | Санхүүгийн ажиллагааны ЦМГ | - | - |
| | Нийт цэвэр мөнгөн гүйлгээ | - | - |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | - |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | - |
| Төсвийн гүйцэтгэлийн тайлан | | | |
| | Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн | - | 2,165,634,577.5 |
| | Урсгал зардал | - | 2,165,634,577.5 |
| | Хөрөнгийн зардал | - | - |
| | Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр | - | 2,267,532,800.0 |
| | Улсын төсвөөс санхүүжих | - | 2,267,532,800.0 |
| | Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас | - | - |

Гурав. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 9,445.5 мянган төгрөгийн алдаа илэрснээс аудитын явцад 9,445.5 мянган төгрөгийн алдааг залрууллаа.

Залруулсан алдаа:

- ДЭМБ-гийн санхүүжилтээр хэрэгжүүлсэн хөтөлбөрийн хүрээнд орчуулгын 800.0 мянган төгрөгийг буцааж төвлөрүүлснийг өөрийн орлогоор тайлагнасан нь УСНББОУС-1, тохиолдсон байх, иж бүрэн байх батламж мэдэгдэл,
- Харилцагч байгууллага "Шунхлай" ХХК-тай хийсэн гэрээний дагуу 3 хувийн урамшуулал 400.0 мянган төгрөгийг тайлан бүртгэлд тусгаагүй, УСНББОУС 1, 12, тасалбар болголт, эрх ба үүрэг батламж мэдэгдэл,
- Эм боом материалын данснаас зарцуулсан 6,034.5 мянган төгрөгийн бараа материалыг дутуу тусгасан нь УСНББОУС 1, 12, тасалбар болголт, эрх ба үүрэг батламж мэдэгдэл,
- Машин тоног төхөөрөмж дансанд бүртгэлтэй компьютерыг Бүрэгхангай сумын ЭМТ-д шилжүүлснийг бүртгэл тайланд тусгасан УСНББОУС 1, 17, тасалбар болголт, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг тус тус хангаагүй байна.

Аудитаар нийт 22,244.4 мянган төгрөгийн зөрчил илэрснээс, 1,888.6 мянган төгрөгийн төлбөрийн 3 акт тогтоож, 3,624.0 мянган төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлж, 16,731.8 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 22,244.4 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 41,319.7 мянган төгрөгөөр бага тул Өөрчлөлтгүй дүгнэлт өглөө.

5.1 Төлбөрийн акт

1. Албан хаагчдад албан томилолтын хугацаанд нийт 755.0 мянган төгрөгийн хоолны мөнгө давхардуулж олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.2, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т заасныг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3.8-д “Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн”

2. Анхан шатны баримтгүй 96.0 мянган төгрөг, томилолтоор ажилласан хоногийг илүү тооцож 120.0 мянган төгрөгийн томилолт олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.7-д заасныг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3.8-д “Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн”

3. Үр дүнгийн урамшууллыг сахилгын шийтгэлтэй нэг албан хаагчид 917.6 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 2.7, Монгол Улсын сайд, ЗГХЭГ-ын дарга, Төрийн албаны зөвлөлийн даргын 2019 оны 36/32 дугаар хамтарсан тушаалын хавсралтын 3.11-т заасныг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3.8-д “Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн”

5.2 Албан шаардлага

1. Тайланд онд ариутгал, халдваргүйжүүлэлт, мэргэч шавж усгалаас 3,101.0 мянган төгрөгийн өөрийн орлого бүрдүүлсэн ч гэрээ хийгээгүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу нь НББ-ын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 13 дугаар зүйлийн 13.1, 13.6-д заасныг бүрэн хэрэгжүүлээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.11-д “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал”

2. "Ижил хангай" ХХК-аас 523.0 мянган төгрөгийн бараа материалыг 1 дүгээр сард авсан ч нярав тухай бүр орлогоор бүртгэж тайлагнаагүй нь НББ-ын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 13 дугаар зүйлийн 13.1, 13.6-д заасныг бүрэн хэрэгжүүлээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.11-д “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал”

5.3 Зөвлөмж

1. Байгууллагын эзэмшилд бүртгэлтэй 6 нэр төрлийн 16,731.8 мянган төгрөгийн элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгүүдийг дахин үнэлээгүй нь Аймгийн ИТХ-ын 2014 оны 17 дугаар тогтоолын хавсралтын 6.1, 6.2, 2018 оны 11 дүгээр тогтоолын хавсралтын 2.4,

2.5-д заасныг бүрэн хэрэгжүүлээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Холбогдох хууль, журмын заалтыг бүрэн хэрэгжүүлж дахин үнэлэх, шийдвэрлэх ажлыг зохион байгуулах

2. Хуулийн цаглаварт хугацаанд санхүүгийн тайланг ирүүлээгүй нь Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасныг хэрэгжүүлээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хуулийн цаглаварт хугацаанд баталгаажсан иж бүрэн санхүүгийн тайланг ирүүлэх

Дөрөв. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

| Байгууллагын нэр | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|------------------|------------|-----|-----------------------------------|-----|--------------------------|-----|------------|-----|--------------|-----|---------|-----|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Залруулсан | | Залруулаагүй | | Тоо | Дүн |
| | | | | | | | Тоо | Дүн | Тоо | Дүн | | |
| ЭМГ | 4 | 9.4 | 1 | 0.4 | 3 | 9.0 | 4 | 9.4 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 |
| Дүн | 4 | 9.4 | 1 | 0.4 | 3 | 9.0 | 4 | 9.4 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 |

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

| Байгууллагын нэр | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|------------------|-------------|------|---------------|-----|-----------------|-----|---------|------|--------------------------------------|-----|---|-----|
| | Тоо | Дүн | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| ЭМГ | 7 | 22.2 | 3 | 1.9 | 2 | 3.6 | 2 | 16.7 | 0 | - | 0 | - |
| Дүн | 7 | 22.2 | 3 | 1.9 | 2 | 3.6 | 2 | 16.7 | 0 | - | 0 | - |

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|--|-------------|-------|---------------|-----|-----------------|-----|---------|-------|
| | Тоо | Дүн | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| ЭМГ | 1 | 496.1 | | | 0 | | 1 | 496.1 |
| Дүн | 1 | 496.1 | | | 0 | | 1 | 496.1 |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| Дүн | 0 | - | 0 | - | 0 | - | 0 | - |
| Нийт дүн | 1 | 496.1 | | | 0 | | 1 | 496.1 |

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

| № | Төсвийн захирагчийн ангилал | Байгууллага, нэгжийн тоо | | | | Санал дүгнэлтийн хэлбэр | | | |
|---|-----------------------------|--------------------------|-----------------------------|--------------------|-----------------|-------------------------|----------------|-------|----------------------------|
| | | Аудитад хамрагдах | Үүнээс: Аудит хийсэн хэлбэр | | | Зөрчилгүй | Хязгаарлалттай | Сөрөг | Дүгнэлт өгөхөөс татгалзсан |
| | | | Санал дүгнэлт гаргасан | Түүвэрт хамруулсан | Аудит хийгээгүй | | | | |
| А | 1 | 2 | 3 | 4 | 5 | 7 | 8 | 9 | 10 |
| 1 | ТШЗ | 1 | 1 | | | 1 | | | |
| | НИЙТ | 1 | 1 | | | 1 | | | |